

**Characterizing Dulam Dashjamt's research works on education, pedagogy and morality**

Enkhbayar Janchivnyambuu, Myagmarsaikhan Purevdorj

Article information**Article history:**

Received: 2024.11.05

Revised: 2024.11.18

Accepted: 2024. 11.20

Keywords:

Pedagogy

Morality

Society

Education

ABSTRACT

Professor Dulamiin Dashajmats was one of the 20th century's most prominent figures in Mongolian philosophy, morality, and education. His groundbreaking work significantly advanced the understanding and development of philosophical and ethical thought in Mongolia, seamlessly integrating traditional Mongolian perspectives with broader intellectual movements of his time. During the socialist era in Mongolia, Professor Dashajmats taught philosophy, ethics, and history, educating four generations of students and profoundly shaping the intellectual and moral landscape of the nation. His teachings laid a robust foundation for critical thinking and ethical reasoning, helping to define Mongolia's academic and moral traditions.

Thus, this presentation delves into his profound works on education and morality, which remain deeply relevant today. They offer insightful perspectives on the dynamic interplay between ethics, education, and cultural heritage. As a scholar, Professor Dashajmats's legacy continues to endure in the realms of education and moral philosophy. His contributions serve as a timeless reminder of the transformative power of intellectual and ethical inquiry in shaping both individual character and societal progress.

Corresponding author:

Myagmarsaikhan Purevdorj

Institute of Philosophy

Email: emiga12@yahoo.com

Дуламын Дашжамцын боловсрол, сурган хүмүүжүүлэх, ёс суртахууны чиглэлээр хийсэн судалгааны тухайд өгүүлэх нь

Жанчивнямбуугийн Энхбаяр, Пүрэвдоржийн Мягмарсайхан

Санал болгож буй эшлэл:

Энхбаяр, Ж., Мягмарсайхан, П. (2024). Дуламын Дашжамцын боловсрол, сурган хүмүүжүүлэх, ёс суртахууны чиглэлээр хийсэн судалгааны тухайд өгүүлэх нь. *Боловсролын Судалгааны Монголын Сэтгүүл, Тусгай дугаар*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.13>

To cite this article:

Enkhbayar, J., Myagmarsaikhan, P. (2024). Characterizing Dulam Dashjamt's research works on education, pedagogy and morality. *Mongolian Journal of Educational Research, Special Issue*. <https://doi.org/10.46328/mjer.si.2024.13>

ДУЛАМЫН ДАШЖАМЦЫН БОЛОВСРОЛ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ, ЁС СУРТАХУУНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТУХАЙД ӨГҮҮЛЭХ НЬ

Философийн салбарын нэрт эрдэмтэн, профессор Дуламын Дашжамц (1930-2015) багш бол тавь гаруй жил их, дээд, дунд сургуульд түүх, философи, ёс суртахууны хичээл зааж, монголын философи, ёс зүй, түүх, нийгэм судлаачдын дөрвөн үеийг бэлтгэсэн алдарт сурган хүмүүжүүлэгч билээ. Зөвхөн эрдэмтэн судлаач, багш сурган хүмүүжүүлэгч байсангүй, эзэмшсэн мэргэжил нь түүхч хэдий ч эх орондоо нийгмийн шинжлэх ухаан, философийн мэргэжлийн эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулах ажилд идэвхийлэн зүтгэж, улмаар Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн анхны захирлын үүргийг гүйцэтгэн, монголд философи, нийгэм судлалыг биеэ даасан орчин үеийн институцийн түвшинд хөгжүүлэх их үйлсийг бүтээлцсэн гавьяатай. Шинэ тутам байгуулагдсан хүрээлэнг төлөвшүүлэх, эрдэм шинжилгээний хамт олныг бүрдүүлэх ажлыг гардан хийсэн шигээ үе үеийн философийн салбарын судлаачдыг бэлтгэх, мэргэшсэн боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх ажилд амьдралаа зориулсан гэхэд болно. Багш маань монголын түүх, философийн олон шилдэг судлаачдыг олж тодруулан хүрээлэндээ ажиллуулж, эрдмийн зэрэг, цол хамгаалуулж, эрдэм судлалын ажилд нь өсгөж өндийлгөсөн юм. Өөрийнх нь судлал шинжилгээний ажлын хувьд хэлэхэд, монголын болоод дэлхийн түүх, марксист ленинист философи, түүхийн материализм, социалист бие хүн, коммунист хүмүүжил, философийн түүх, монголын философийн түүх, монгол сэтгэгчдийн гүн ухаан, нийгэм, улс төрийн сэтгэлгээ, ёс суртахуун, зан суртлын үзэл, түүхэн хүний намтар зэрэг олон төрөл сэдвээр 40 гаруй ном товхимлыг дангаар болон хамтран бичиж, 80 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг хэвлүүлжээ. Багшийн үлдээсэн олон талт судалгааны баялаг өв уламжлалаас монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн чиглэлээр хийсэн судалгааны тухайд өмнө нь бид нэг бус удаа танилцуулж байсан. Энэ удаад боловсрол, сурган хүмүүжүүлэх, ёс суртахууны чиглэлээр хийсэн ажлыг тоймлон өгүүлэхийг хичээв.

XX зууны эхээр Монгол оронд марксист үзэл суртал дэлгэрч, энэ үзэл суртлаар нийгэм-улс төрийн байгууламж, эдийн засгийн бүтцээ тодорхойлох болсон билээ. Капиталист бус хөгжлийн замаар социализм байгуулах, улмаар коммунизмд хүрэх лут зорилго тавьж, шинэ хүн төлөвшүүлэх, коммунист хүмүүжил, ёс суртахууны онол, номыг боловсруулах, сурталчилан дэлгэрүүлэх ажилд тэр үеийн боловсрол, шинжлэх ухааны салбарыг бүхэлд нь чиглүүлж байсан. Тэр дундаа социалист бие хүн бий болгох асуудал 1950-80-аад онд эрчимтэй судлагдах болж, эрдэм судлалын биеэ даасан нэг салбар болтол хөгжсөн ажээ. Социалист нийгэм байгуулах үзэл суртал, марксист-ленинизмийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх үйл хэрэгт тэр үеийн бүх л эрдэмтэн, багш, сурган хүмүүжүүлэгч, сэхээтнүүд зүтгэж байсан нь Д.Дашжамц багшид мөн холбогдоно. Тиймээс 1990 оноос өмнөх багшийн боловсрол, сурган хүмүүжүүлэх ухааны чиглэлээр хийсэн судалгааны үндсэн ажил нь социалист бие хүнийг хүмүүжүүлэх, социалист ёс суртахууны төлөвшлийн сэдэв байлаа.

Д.Дашжамц багш ид бүтээлч үедээ Марксизм-Ленинизмийн монголд дэлгэрсэн асуудлыг нэлээд хугацаанд тусгайлан судалж, “Монголд Марксизм-Ленинизм дэлгэрэн хэрэгжсэн нь (1917-1940)” (Дашжамц, Д. 1978), “БНМАУ дахь Марксист сэтгэлгээний хөгжилт (1940-1960)” (Дашжамц, Д. 1978), хэмээх бүтээлүүд туурвиж, түүнчлэн эрдмийн зэргээ энэ сэдвээр хамгаалсан юм. Монголд марксизм дэлгэрэх хөрс бүрэлдсэн учир шалтгаан, улмаар марксизм-ленинизмийн үзэл санааг хүлээн авч эх орондоо социализм байгуулах үйл явцыг өгүүлэн, эцэстээ монголчууд марксист философи, нийгмийн үзэл санааг нь системтэй судалж, философи, нийгэм-улс төрийн судалгаа шинжилгээ хөгжиж байгаа байдлыг нэр бүхий бүтээлүүдээр он цагийн хэлхээ холбоо, дэс дарааллаар харуулсан байна. Марксизм нь дорой буурай Монголын хувьд шинжлэх ухаан, нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлийн чухал хүчин зүйл болж, суурин иргэншлийн хамаг сайн ололтуудыг, тэр дундаа орчин үеийн боловсролын тогтолцоог нэвтрүүлэн шинэ ажил, мэргэжлийн хүмүүсийг, сэхээтний давхаргыг бүтээсэн сайн талыг онцолдог байлаа.

Социалист монголыг бүтээх, боловсрол, хүмүүжилтэй монгол иргэдийг төлөвшүүлэх итгэл үнэмшлээр, мөн эх орон, нийгмийн өмнө хүлээсэн эрдэмтэн хүний үүргээ биелүүлж, Д.Дашжамц багш социалист ёс суртахуун, коммунист хүмүүжлийн тухай, социалист аж төрөх ёсны тухай олонтаа бичсэн. Бүр тодруулан өгүүлбээс, “Хүүхдийн насны бие махбодийн ба сэтгэхүйн зүйн онцлог” (Дашжамц, Д. 1960), “Коммунист хүмүүжил” (Дашжамц, Д. 1967), “Монголын ард түмний ёс суртахууны хүмүүжлийн дэвшилт уламжлалаас” (Дашжамц, Д. 1968), “Хүн хүмүүжил, ёс суртахуун” (Дашжамц, Д. 1978), “Коммунист хүмүүжлийн үндэс” (Дашжамц, Д. 1984), зэрэг нэгэн сэдэвт бүтээл, товхимлыг хэвлүүлжээ. Мөн

“Марксист-ленинист ёс зүйн үндэс”, “Коммунист ёс суртахууны үндэс” (Дашжамц, Д. 1982), “БНМАУ дахь социалист бие хүний төлөвшил, хөгжлийн асуудал” (Дашжамц, Д. 1989), “Эрх зүй-ёс суртахуун” (Дашжамц, Д. 1987), “Монголын ёс зүйн сэтгэлгээний түүх” (Дашжамц, Д. 2009), зэрэг хамтын бүтээл, дунд сургуульд үзэх сурах бичгийг бичжээ. Эдгээр ажлын гол агуулга нь социалист нийгэмд тохирох хамтач үзэл, эх оронч хүмүүжил, эрх зүйн мэдлэг, ёс суртахуунтай хүмүүнийг бэлтгэх, нийгмийн иргэн болгож төлөвшүүлэх явдал байв. Одоогийн хүний хөгжлийн асуудал ярьж хэлэлцүүлдэгтэй утга нэг юм. Хэдийгээр үзэл суртлын үүднээс бичиж ирсэн ч бид зохистой бөгөөд зүйтэй үг, сургаалыг нь, ёс суртахуун, хүмүүжлийн онолын түгээмэл шинжтэй зүйлсийг авах гээхийн ухаанаар өвлөн авч эдүгээ цагийн боловсрол, хүмүүжлийн асуудалд тусгах нь зайлшгүй зүйл болно. Аливаа хүний ертөнцийг үзэх үзэл төдийгүй философи, нийгмийн ухааны эрдэмтдийн үзэл санаа, бүтээлүүд тухайн нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн баримталж буй үзэл суртлынх нь тусгал болж гарч ирдэг билээ.

Д.Дашжамц багшийн хүмүүжлийн талаар бичсэн бүтээлүүд бол монгол хүнийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд ач холбогдолтой үзэл санаагаар баялаг. Хүмүүжлийн тухайд түүний үндсэн зорилго бол социалист маягийн бүхэл бүтэн бие хүнийг төлөвшүүлэх явдал бөгөөд тэр нь бие хүнийг марксист-ленинист ертөнцийг үзэх үзэл, ёс суртахууны баялаг байдал, үзэл санааны чиг, мэргэжлийн бэлтгэл, бүтээлч эрмэлзлийн нэгдлээр тодорхойлогдоно гэж үзэж байв (Дашжамц, Д. 1978). Хүмүүжил нь заяамал зүйл биш, харин “хүнд оюун ухаан, ёс суртахуун, гоо сайхан, хөдөлмөр, бие бялдрын тодорхой чанаруудаар хүмүүжүүлэхээр дэс дараалал, чиглэл зорилготой, ухамсартай нөлөөлөхийг хэлнэ” (Дашжамц, Д. 1978) гэж тодорхойлсон буй. Хүмүүжлийг нийгмийн нөлөөгөөр, ясли, цэцэрлэг, сургуулийн нөлөөгөөр нийгэм, хамт олны нөлөөгөөр өөрчлөгдөн хүмүүжиж болохыг мөн тэмдэглэжээ. Ямар нийгэм байгуулахыг хүснэ, тийм иргэдийг л хүмүүжил, ёс суртахууны номлолоор бэлтгэдэг болохыг багшийн бүтээлүүд харуулж байна. Социалист нийгэмд оюун ухааны хүмүүжил, ертөнцийг үзэх шинжлэх ухааны үзэл, бие бялдрын хүмүүжил, техникийн олон талын боловсрол, гоо сайхны хүмүүжил зэргээр олон талын хүмүүжилтэй хүн бэлтгэхийг тэргүүн зорилго болгож байв. Одоо хүн бэлтгэх, төлөвшүүлэх хүмүүжлийн агуулгатай бичих, айлдах нь ховордож, хүмүүжлийн ажлын үр нөлөөнөөс илүү боловсролын өөрчлөлт, ёс суртахууны уналт, доройтол зэрэг асуудал хамгийн их ярьж хэлэлцдэг болжээ. Угтаа бол хүмүүжлийн асуудал боловсролын салбарын онцлон анхаарч үзэх ёстой нэг чухал хэсэг юм. Гэхдээ хүмүүжлийн гүн ухаан, хүмүүжлийн философи зэргээр хэт хүндрүүлж онолдоод байх хэрэггүй юм. Бага, дунд сургуульд гэхэд сурагчдын анхаарлаа төвлөрөх, цагаа зөв өнгөрөөх, эрүүл сурах орчин бүрдүүлэх, зорилготой, зөв хувийн зохион байгуулалттай амьдрах арга барилыг зөв хүмүүжлийн дадал зуршил суулгаж л бий болгоно. Тэгэхээр онолоос илүү практик асуудал буюу боловсрол, хүмүүжлийн прагматик зарчим баримтлах нь одоогийн нөхцөлд оновчтой гэж үзэж байна.

Ёс суртахууны сэдвээр Д.Дашжамц багш нөр их хөдөлмөрлөж, коммунист ёс суртахуун, түүний үндсэн зарчмуудыг тодорхойлж, социалист үйл хэрэгт үнэнч байх үзэл, хөдөлмөр болон нийгмийн өмчид социалист ёсоор харилцах үзэл, хамт олонч үзэл, социалист хүнлэг энэрэнгүй үзэл зэргээр тал бүрээр үндэслэн бичиж байжээ. Зөвхөн үзэл суртлын үүднээс бичээгүй, ёс суртахууны түгээмэл зарчим, ухагдахуунууд болох сайн ба муу, шударга ёс, үүрэг, нинжин сэтгэл, нэр төр, аз жаргалын талаар дэлгэрэнгүй бичиж сурталчилж байсан юм. Түүнчлэн монголын ард түмний ёс суртахууны дэвшилт уламжлал, зан суртахуун, хэм хэмжээг ардын аман зохиол, дуу хуур, үлгэр туульс, оньсого, таавар, зүйр цэцэн үгсийн эх сурвалжаас тодотгон өгүүлж, Хуульч Сандаг, яруу найрагч Инжинаш, шүлэгч Данзанванжил, ерөөлч Гэлэгбалсан зэрэг билэг төгөлдөр бичгийн мэргэдийн зохиол бүтээлүүдийг судлан шинжилж, ардын уламжлалт ёс суртахуун, аж төрөх ёсыг үнэлж дүгнэсэн билээ. “Манай монголын ард түмний ёс суртахуунд хүн яаж ажиллаж, амьдарч, хоорондоо яаж харилцах, хэрхэн биеэ авч явбал зохихыг маш нарийнаар зааж өгсөн үнэ цэнэтэй сургаал их бий.” (Дашжамц, Д. 1978). Манай ард түмэн “үр хүүхдээ эрдэм номтой, залхуу хойргогүй, эрэлхэг баатарлаг, эрүүл чийрэг, хөдөлмөрч хичээнгүй, сэцэн шударга, дээдэд зусаргүй, ядуу дорд хүнийг энэрэн хайрладаг, гоо сайхан хүн болгох” гэсэн ёс суртахууны сайн чанарууд байгааг олон эх сурвалжаар нотлон бичсэн. Монголчуудын ёс суртахууны уламжлал үлэмж болохыг дурдаад “тэрхүү уламжлалт сайхан хэв заншлыг эс хүлээн авбал ёс суртахууны хувьд доголдож, нийгэмдээ гарз хохирол учруулах болно. Хоосон хувьсгалчирхаж ард түмний ёс суртахуун, зан заншлын өв уламжлалыг үл тоомсорлон шууд л цоо шинэ зүйл эрж хөөцөлдвөл хавар болоогүй байхад хөхөөг донгодуулах гэсэнтэй адил үлэмж бүтэхгүй хэрэг тарина. Ингэвэл нийгмийн хамгийн нарийн ээдрээтэй хүмүүжлийн асуудалд бүдүүлэг нугалаа гарч шинэ нь амьдралд тууштай нэвтрээгүй байхад хуучны юмыг мартваас хүмүүсийн

нэгэн үе цалгардаж олтгойдно” (Дашжамц, Д. 2020) хэмээн бичсэн нь өнөөгийн бидний байгаа байдлыг онож хэлсэн мэт санагдана. Монголчуудын “ёс суртахууны дэвшилт уламжлалд их анхааралтай хандаж, түүний баялаг туршлагаар эдүгээ ба ирээдүйн иргэдийг хүмүүжүүлэх нь их ашигтай юм” гэж мөн захиж үлдээжээ.

Монголын философи, нийгэм-улс төр, ёс суртахууны сэтгэлгээний түүхийг судлах ажил XX зууны хоёрдугаар хагасаас эхэлж, монголын түүхэнд болж өнгөрсөн улс төр, нийгмийн чухал үйл явдлууд хийгээд түүхийн зохиол, ёс суртахууны сурвалж бичгүүдийг нягтлан шинжилж, философи, ёс суртахууны үзэл санааны тоймыг харуулсан бүтээлүүд гарах болсон байна. Үүгээр монголын нийгэм-улс төр, ёс зүйн сэтгэлгээний түүхийн судалгааны зорилго, зорилт, онол, арга зүйн баримтлал, зарчмууд тогтож, энэ чиглэлийн судалгааны цаашдын суурь тавигдсан гэж хэлж болно. Ийнхүү Д.Дашжамц багш монголын нийгэм-улс төр, ёс зүйн сэтгэлгээний түүх хэмээх судалгааны биеэ даасан чиглэлийн эхлэлийг, түүнчлэн философи, ёс суртахууны судалгааг дагнан хийх эрдмийн хүрээлэнгийн шавыг тавьсан хүмүүсийн нэг мөн юм.

1990 оны нийгмийн өөрчлөлтөөр монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийг лавшруулан судлах шаардлага улам бүр тавигдах болов. Энэ удаад коммунист хүмүүжил, ёс суртахууны асуудал биш, харин үндэсний уламжлалт соёл, ёс зүй, гүн ухааны үзэл санааны элементүүдийг судлан гаргасан ардчилсан монголын хөгжлийн дүр зургийг бүтээх зорилго тавигдсан болно. Энэ үеэс Д.Дашжамц багш Монголын философийн түүхийн цуврал 5 боть (одоогоор дөрвөн боть гарсан байгаа болно) гаргах ажилд шамдан зүтгэж, 1-р ботийн эртний монголчуудын ертөнцийг үзэхүй бүлгийн 1-р зүйл, 3-р бүлгийн эртний монголчуудын зан суртахууны сэтгэлгээ хийгээд 4 дүгээр ботид монголын утга зохиолын томчууд болох Инжинаш, Хишигбат, То Вангийн аж төрөхүйн сургаалиар бүлэг зүйлүүд бичсэн болно. Түүнчлэн “.. зохиолчдын бүтээлд гүн ухааны сэтгэлгээний шинжийг ямар нэг хэмжээгээр агуулж байдаг.” (Гүн ухаан нийгмийн сэтгэлгээ) хэмээн XX зууны бичгийн их хүн Ц.Дамдинсүрэн гуайн нийгэм-улс төрийн үзэл санааны тухай өгүүлэл хэвлүүлжээ. Ер нь багшийн судалгааг тогтож сайн анзаарах юм бол тухайн хүний амьдрал, зохиол бүтээл, үзэл санаа, сэтгэлгээний хэв маяг зэргийг сайн тусгаж, утга төгөлдөр, зүйрлэл ихтэй бичдэг онцлогтой юм. Дээр дурдсан “Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд” товхимолдоо Их хүрээний хамбо номун Агваанхайдав, их зохиолч Инжинааш, Данзанванжил, Хишигбат нарын зохиол бүтээлд тусаж илэрсэн нийгмийн тэгш бус байдал, мөлжлөг дарлалыг эсэргүүцсэн, хар, шар феодалуудын эсрэг шүүмжлэлт сэтгэлгээ болон ёс суртахууны үзэл санааны онцлог шинжийг өгүүлсэн байна.

Д.Дашжамц багш Хэнтий аймагт дунд сургуульд анги даасан багш нь байсан, хожим их сургуулийн түүхийн ангид хамт суралцаж төгссөн Л.Бат-Очирын хамт “Дамдингийн Сүхбаатар” хэмээх намтар зохиол бичсэн нь тухайн үеийн шилдэг, өнөөгийн хэллэгээр бестселлер ном болж байлаа. Энэ ном орос, япон зэрэг гадаадын хэд хэдэн хэлээр хэвлэгдсэн. Намтар зохиол гэдэг тэр хүний нийгэмд эзлэх байр суурь, үзэл санаа, өв уламжлал, гавьяат үйлсийг нийтэд таниулж, үлгэр дууриаллаар хойч үеэ хүмүүжүүлэх, сурган, ёс зүйн их ач холбогдолтой байдаг. Бурхан багшийн цадиг гэхэд ерөөсөө л хүнийг гэгээрэл ухааралд шамдахыг, гэм нүглийг тэвчиж, гагцхүү буяныг үйлдэж явахыг сургасан агуулгатай байдаг билээ. Бүр хожмоо “Академич, гүн ухаантан, нийгмийн нэрт зүтгэлтэн Д.Төмөр-Очирын намтар” хэмээх зохиол бичиж, орчин цагийн монголын нийгэм-улс төрийн хүрээнд өрнөсөн эмгэнэлт үйл явдлыг үнэн зөвөөр бичиж үлдээх, ухаалаг, ёс суртахууны өндөр төлөвшилтэй, билэг авьяастай эрдэмтэн байсныг залуу үедээ ойлгуулах зорилготой байжээ.

Дуламын Дашжамц багш бээр монголын философийн түүхийн судалгааг эхлүүлсэн анхдагчдын нэг, марксизм-ленинизмын үзэл санааг олон талаас сайтар судалсан эрдэмтэн, “ёс зүйгүй хүн ёр чөтгөрөөс дор” гэсэн ёс суртахууны уриа дуудлагатай сурган хүмүүжүүлэгч, олон шавиа хөлийг нь дөрөөнд гарыг нь ганзаганд хүргэсэн ачлал буянтай хүн байлаа. Эдүгээ дэлхий даяараа олон төрлийн “хямралын” төлөв байдалд байна. Ийм эгзэгтэй цаг үед Д.Дашжамц нарын ухаант өвөг дээдсээ санан дурсаж, эргэцүүлэн бодох сэтгэлгээний үр дүн болсон философи, ёс суртахууны бүтээл туурвилыг нягтлан шинжиж, алс хэтэд хэрэгтэй, тустайг авах нь нэн чухал билээ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Дашжамц, Д. (1973). Монголд Марксизм-Ленинизм дэлгэрэн хэрэгжсэн нь (1917-1940). Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1978). БНМАУ дахь Марксист сэтгэлгээний хөгжилт” (1940-1960). Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1960). Хүүхдийн насны бие махбодийн ба сэтгэхүйн зүйн онцлог. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1967). Коммунист хүмүүжил. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1968). Монголын ард түмний ёс суртахууны хүмүүжлийн дэвшилт уламжлалаас. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1978). “Хүн хүмүүжил, ёс суртахуун” Улаанбаатар.
- Дашжамц, Д. Лувсанцэрэн, Г., (1984). Коммунист хүмүүжлийн үндэс. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1982). Коммунист ёс суртахууны үндэс. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (2020). Монголын философичдын өв. х.14. Улаанбаатар.
- Гүн ухаан нийгмийн сэтгэлгээ 2000/
- Дашжамц, Д. (1989). БНМАУ дахь социалист бие хүний төлөвшил, хөгжлийн асуудал. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (1987). Эрх зүй-ёс суртахуун. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (2009). Монголын ёс зүйн сэтгэлгээний түүх. Улаанбаатар.